Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл - ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | | 7 | 8 |
| Нэг. Стратеги төлөвлөгөөний зорилго: "Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.4 "Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт" чиглэлийн 3.4.2 зорилтын хүрээнд Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын таатамжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн ашиглах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг багасгаж, улс орны дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | | |
| 1. | Зорилт**1**: Цаг уур, орчны шинжилгээний салбарын санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, гадаад, дотоод хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүү, бүртгэл, төсвийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, үр ашигтай зарцуулах, тайлагнах, Байгууллагын хөрөнгө оруулалтын болон урсгал төсвийн үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, хянах, тайлагнах, үр дүнг тооцох, байгууллагын батлагдсан төсвийг зарцуулах, тайлагнахад дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж | Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо, төсөв, гэрээний хэрэгжилт, Холбогдох хууль, журмын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх арга хэмжээнүүдийн гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хөрөнгө оруулалт барилга байгууламжийн төсөв 13,6 тэрбум төгрөг, Тоног төхөөрөмж 105,0 сая төгрөг. Салбарын хэмжээнд Их засварт 1,9, орчны шинжилгээний ажил, тоног төхөөрөмж 2,0 тэрбум, тоног төхөөрөмж, эко ариун цэврийн байгууламж 3,4 тэрбум, цаг уур, ус судлалын харуулыг автоматжуулах 4,5 тэрбум, орчны шинжилгээний багаж, техник, сүлжээний өргөтгөл 2,0 тэрбум төгрөг Нийт 27,5 тэрбум | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,0 тэрбум төгрөгөөр ус, цаг уурын автомат станц 20-ийг худалдан авах, 2,1 тэрбум төгрөгөөр төв байрны засварын ажил, 0,8 тэрбум төгрөгөөр 9 байгууллагын 11 их засварын ажил, 20 харуулын мотоцикль, өндөр хүчин чадлын суурин комьютер 10ш, өртөөний 18-21 байрилга, ус, цаг уурын харуулын 50-80 барилгыг тус тус шийдвэрлэх | | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 хөрөнгө оруулалт батлагдсан 6,5 тэрбум төгрөгөөр "Байгаль орчин, цаг уурын салбарын орон нутаг дахь өртөө, харуул, байгаль хамгаалагчийн байр (бүсүүдэд)" барих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгөөр цаг уурын 20 Өртөөний, 17 усны харуулын байрыг шинээр барихаар шийдвэрлэн, байрны зураг, төсвийг шинэчлэн инноваци шингэсэн, эрчим хүч хэмнэлттэй, дулааны алдагдал багатай байдлаар хийлгэн, 9 багц болгон Төрийн худалдан авах газарт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулуулахаар хүргүүлсэн. Уг арга хэмжээнээс 5 багцын гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. | 82,9 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төгрөг. Солонгосын төсөл 2,1 сая америк доллар. Урсгал төсөв 66,1 тэрбум төгрөгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан. | | 4 багцын гүйцэтгэгч шалгараагүй байна. Салбарын их засварт 2,0 тэрбум төгрөгөөр төвийн байрны их засвар, 8 аймгийн 10 өртөөний барилгын болон сантехникийн засварыг хийхээр шийдвэрлэж 2 ажлын гэрээ байгуулагдсан. Бусад ажлын гүйцэтгэгч сонгогдоогүй байна. Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн тендер зарлагдсан. | |
| 2. | Арга хэмжээ 1.1 "Цаг уур, орчны шинжилгээний салбарын 2026 оны хөрөнгө оруулалт, урсгал төсвийн төсөл боловсруулах, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд санал хүргүүлэх | Улсын төсөв Хуулийн хугацаанд холбогдох журмын дагуу төсвийн болон хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн байдал, хэрэгжилтийн хувь | Улсын төсөв Хуулийн хугацаанд холбогдох журмын дагуу төсвийн болон хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн байдал, хэрэгжилтийн хувь | Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах санал, урсгал төсвийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд хүргүүлж батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан | Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах санал, хуулийн хугацаанд хүргүүлж, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна | 2025 оны эхний хагас жилд газрын 2026 оны урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсөв, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд саналыг тооцооны нягтлан бодогчоор хэлтсүүдээс саналыг нь авахуулж, боловсруулж хянаж шалган авч, салбарын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг төсвийн мэргэжилтэнтэй хамт хянаж шалган буруу хийсэн байгууллагуудад утсаар мэдэгдэж, заавар зөвлөмж өгч дахин засуулж, газрын даргад танилцуулж хуулийн хугацаанд БОУАӨЯаманд хүргүүлж ажилласан. | 100 |
| 3. | Арга хэмжээ 1.2 Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байрны зоорины давхарт ус нэвчилтийг гүйцэтгэгч компаниар нэмэлт ажил хийлгэх /Улаанбаатар/, | Улсын төсөв | Зоорины давхарт ус нэвчилтийг зогсоох ажил хийгдсэн байх | Гүйцэтгэгч "Чинбат" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу барьцаа хөрөнгөөр хийлгэх санал гаргасан | Барилга хөгжлийн төв, Гүйцэтгэгч "Чинбат" ХХК-аар нэмэлт ажил хийгдсэн байна. | "Чинбат" ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг хүлээн авсанаас хойш зоорийн давхарaр их хэмжээний ус нэвтрэн хана шал эвдэрч, өвөлдөө хөлдсөн мөстөх, ойр орчмын өрөөний паарыг хөлдөөх, дулаан алдалт ихтэй байгаас ажиллах хэвийн нөхцөл алдагдаж байгаа талаар мэдэгдэл албан тоотоор хүргүүлсэн. "Чинбат" ХХК-нь Бүрэн Трейд девелопмент ХХК-тай хамтран ажиллах | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрэ байгуулан 6/2 өдөрөөс 6/10 хооронд ажлын 10 хоногт хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан гэрээ, болон албан бичгийн хамт ирсэн боловч өнөөдрийг хүртэл гүйцэтгэгч компани ажлаа эхлүүлээгүй байна. “Чинбат” ХХК-ийн чанарын баталгааны 69,388,916 төгрөгийг суллах санал тавьсанг боломжгүй гэдэг хариуг өгсөн болно. | |
| 4. | Арга хэмжээ 1.3 Ус цаг уур, орчны шинжилгээний төв болон өртөө, харуулын барилга барих; /2024 онд гэрээ нь хийгдсэн цаг уурын өртөөний их засварын ажил/ 2024-2025 онуудад шилжих, шинээр барих 3 төвийн барилга, цаг уурын өртөөний барилга 3 барина. 2025 онд шинээр өртөөний 18-20, харуулын 50-80 барилга шинээр барих | УТ-ХО | Шинээр барих өртөөний байр, харуулын байрын ажлуудын зураг төсвийг шинэчлэн батлуулж, гүйцэтгэгчийг сонгосон, он дамжсан ажлуудын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал | 2024 онд шилжих Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байрны үлдэгдэл санхүүжилт-1,387.8 сая төгрөг, (Улаанбаатар), Өвөрхангай Хужирт сумын цаг уурын өртөөний барилга-222.8 сая төгрөг, Баянхонгор, Баянхонгор сум-500.0 сая төгрөг, Өвөрхангай, Арвайхээр сумын Цаг уурын өртөөний барилгын 753.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож ажилласан. Өртөөний байрны нэг маягийн зураг, төсөв шинэчлэх, харуулын байрны зураг төсөв байхгүй. | 2024-2025 онуудад шилжих, шинээр барих 3 төвийн барилга, цаг уурын өртөөний 3 барилгын ажлыг эхлүүлж хэрэгжилтэд хяналт тавих, 2025 онд шинээр барих өртөөний нэг загварын зургийг шинээр хийлгэх, харуулын барилгын зураг хийлгэнэ. Гүйцэтгэгчийн гэрээний үүрэгээ биелүүлэхэд хяналт тавьж, хүлээн авахад оролцох | 2024-2025 онд гэрээ шилжин хийгдэх өртөө, төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч компаниуд үргэлжлүүлэн хийж байна. 2025 онд цаг уур, усны харуулын байрны болон өртөөний байрны зураг төсвийг эрчим хүч, дулаан хэмнэлттэй, инноваци шингэсэн зураг төсвийг шинээр батлуулан, Өртөө, харуулын байр барих аймаг, сумдын газрын болон дэд бүтцийн зураг, зөвшөөрөлийг авсан. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 хөрөнгө оруулалт батлагдсан 6,5 тэрбум төгрөгөөр сайдын А/237 тушаалаар “Байгаль орчин, цаг уурын салбарын орон нутаг дахь өртөө, харуул, байгаль хамгаалагчийн байр (бүсүүдэд)” барих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгөөр цаг уурын 20 Өртөөний байр, 17 усны харуулын байрыг шинээр барихаар шийдвэрлэн, 9 багц болгон Төрийн худалдан авах газарт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллуулахаар хүргүүлсэн. Өртөөний барилгын 3 багц 13 барилгын ажил, харуулын байрны 2 багц буюу 9 аймгийн харуулын байр барих ажлын гүйцэтгэгч компани тус тус шалгараад байна. Цаг уур, орчны шинжилгээний газрын байрны их засварын ажилд “Хүрэл соёмбо ХХК” шалгарсан, А/127-р тушаалын дагуу их засварын ажилд Хөвсгөл, Сэлэнгэ, Баян-Өлгий аймгийн их засвар хийх компани шалгарч, Баян-Өлгий аймгийн Дэлүүн өртөөний их засварын ажил хийгдээд аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хүлээн авах шатандаа ажил явагдаж байна. 4 багцын гүйцэтгэгч шалгараагүй байна. Мотоцикпь 20 ш, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн тендер зарлагдсан. | |
| 5. | Арга хэмжээ 1.4 Ус цаг уурын салбарын тоног төхөөрөмж шинэчлэх 10 усны харуулын автомат станцыг, цаг уурын өртөө, харуулын 10 автомат станц, ЦАЗН үйл ажиллагааг дэмжин газрын генератор дагалдах түлшний хамт авах төсвийн саналыг яаманд хүргүүлэх, шийдвэрлүүлэх | Улсын төсөв | Автомат багажаар хангагдсан Ус, цаг уурын өртөө, харуулын тоо | 2024-2025 онд усны харуулын 10, цаг уурын өртөөний 10 автомат станц авч суурилуулсан. | 2.0 тэрбум төгрөгийн төсвийн үндэслэл хэрэгцээ шаардлагын талаар мэдээлэл хүргүүлж төсвийг батлуулна. | Сайдын багцаас усны харуулын 10, цаг уурын өртөөний 10 автомат станц авч авах хөрөнгийн асуудал шийдэгдсэн, Яаманд болон Төрийн худалдан авах газарт тухайн багажийн техникийн тодорхойлолтыг гарган өгч, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. ЦАЗН үйл ажиллагааг дэмжин Хангайн бүсэд суурин радарыг Хархоринд байгуулахаар Засгийн газрын хурлаар шийдвэрлүүллээ. Газрын урсгал төсвийн хөрөнгөөр пүүжин, мөндөр сарниулагч авахаар нээлттэй тендер зарлан худалдан авах | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. | |
| 6. | Арга хэмжээ 1.5 Ус цаг уур, орчны шинжилгээний төв, өртөө харуулын байр, дулаан хангамж, сантехникийн засвар хийх | Улсын төсөв | Засвар хийсэн байрны тоо | 15 байгууллагын 29 их засварын ажлыг 1,9 тэрбум төгрөгөөр хийсэн. | Салбарын төвүүд, өртөө харуулаас нэн шаардлагатай засвар хийх газруудыг сонгон, нийт 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг БОУАӨЯ-нд хүргүүлж шийдвэрлүүлэнэ. Гүйцэтгэлд хяналт тавина. | Сайдын 2025 оны А/127 дугаар тушаалаар цаг уурын салбарт 8 аймгийн 11 өртөөний барилгын болон сантехникийн их засварын ажилд 800,0 сая төгрөг, Төв байрны засварт 1,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Уг ажлуудын зураг төсвийг батлуулж, худалдан авах ажлыг зохион байгуулсанаас төвийн байрны их засвар, өртөөний байрны засварын 2 ажлын гэрээ байгуулагдсан. Бусад ажлын гүйцэтгэгч сонгогдоогүй байна. | 40 |
| 7. | Арга хэмжээ 1.6 Ус цаг уур, орчны шинжилгээний салбараас Монгол улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах саналаа боловсруулж, харьяалагдах дээд шатны байгууллагад хүргүүлэх, хамгаалах | Улсын төсөв | Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд хүргүүлсэн байдал /Саналын тоо/ | 26 байгууллагын 2025 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд Сангийн яамд хүргүүлж, FISCAL программд шивж оруулан, нэгтгэн боловсруулсан. | 26 байгууллагын 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд Сангийн яамд хүргүүлж, FISCAL программд шивж оруулан, эхний хагас жилийн мэдээ тайланг нэгтгэн боловсруулсан байна. | 26 байгууллагын 2025 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт оруулах саналыг хуулийн хугацаанд Сангийн яамд хүргүүлж, FISCAL программд шивж оруулан, нэгтгэн боловсруулсан. Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДТТХМ) болон төсвийн хязгаарт тусгах саналаа Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу хугацаанд боловсруулан хүргүүллээ. 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах ажлыг салбарын хэмжээнд төлөвлөн төсөл, арга хэмжээ, зардал бүрээр саналыг авч, ангилан харъяа 26 байгууллагаас саналыг авч нэгтгэн боловсруулж, Салбарын үйл ажиллагааны үр өгөөжийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдүүлэх, үндэсний хэмжээнд байгаль орчны тогтвортой хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлэх, хүний нөөц, техник технологийн чадавхыг сайжруулах, хөрөнгө оруулалтын хэрэгцээг бодитоор тусгасан болно. Боловсруулсан төсвийн саналд салбарын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийн төсөвт өртөг, хэрэгжүүлэх үндэслэл, үр өгөөж, хүрэх үр дүнг нарийвчлан тусгаж, шаардлагатай тоон болон чанарын мэдээллээр бүрэн хангаж боловсруулсан. Тус саналыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хугацаанд нь хүргүүлж, тус яамнаас Сангийн яаманд уламжлан, хамгаалан танилцуулах үйл ажиллагаанд хамтран оролцож, дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна. | |
| 8. | Арга хэмжээ 1.7 “Цаг уур, орчны шинжилгээний салбарын 2026 оны хөрөнгө оруулалт, урсгал төсвийн төсөл боловсруулах | Улсын төсөв | Улсын төсөв Хуулийн хугацаанд холбогдох журмын дагуу төсвийн болон хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн байдал, хэрэгжилтийн хувь | 2024 оны урсгал төсвийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд хүргүүлж батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан | 2025 батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна, Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллана. | БОУАӨЯ-ны 2025 оны 05 дугаар сарын 07-ны 09/2282 тоот албан бичгийн дагуу Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтын саналаа ttps://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системээр 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор хүргүүлэхээр Цаг уур, орчны шинжилгээний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | салбарын барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, Зураг төсөв,ТЭЗҮ-ийн саналыг нэгтгэн авч цахим системд нэгтгэн оруулаад байна. Үүнд Хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга байгууламж 12 аймгийн 26,955.4 тэрбум төгрөг, 16 аймгийн 3,140.8 төгрөгийн их засвар Улаанбаатар хот болон 10 аймаг ус судлалын 30 харуулыг автоматжуулах, 15 аймаг 10 сум 10 өртөө харуулд автомат станц суурилуулах 43,555.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, 4 аймгийн 332.5 төгрөгийн зураг төсөв, ТЭЗҮ-ийн санал тусгагдлаа. | |
| 9. | Арга хэмжээ 1.8 Салбарын болон агентлагийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавих | Улсын төсөв | Салбарын болон байгууллагын батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулахад хяналт тавьсан явц | Харьяа байгууллага болон газрын 2024 онд хүрэлцэхгүй зардлыг тооцож, хэмнэгдэж байгаа зардлын төсвөөс зохицуулалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлэн зохицуулж ажилласан. | 2025 оны 1-6 сард санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавьсан байна. | 2025 эхний хагас жилд Газрын болон салбарын байгууллагуудын санхүүжилт, эрх олгох, өөрчлөлт оруулах хүсэлтийг нэгтгэн яаманд хүргүүлэн ажиллаа. 2025 оны эхний хагас жилийн байдлаар газрын даргын хөрөнгө зарцуулах 22 ширхэг тушаалын төслийн холбогдох хуулийн заалт, төсвийг нь хянаж ажилласан. | 90 |
| 10. | **Арга хэмжээ 1.9** "Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулахад нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах | Улсын төсөв | Төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулалтад хяналт тавьсан байдал, үйл ажиллагааны хэрэгжилтийн явц | 2023 оны жилийн эцсийн тайлан, 2024 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн гаргаж Сангийн яамны Э-тайланд шивж БОАЖЯ-нд хүргүүлсэн. | 2024 оны жилийн эцсийн аудит хийгдсэн санхүүгийн тайланг нэгтгэн Сангийн яамны Э-тайланд шивж, БОУАӨЯ-нд хүргүүлнэ. | Газар болон харьяа байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн холбогдох журнал болон ерөнхий данс, тооллого, тооцооны материалтай тулган шалгаж хуулийн хугацаанд нэгтгэж, нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргаж Үндсэний аудитын газарт хүргүүлж санхүүгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтуудыг шалгуулж шаардсан судалгаа, тооцоог нэг бүрчлэн гаргаж ажилласан. Аудитын шалгалтаар 26 байгууллагаас түүвэрт 9, 3 байгууллага хязгаарлалттай, 14 байгууллага "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч ажилласан.<br>Мөн Сангийн яамны Э-тайланд 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг шивж, байгууллага тус бүрээр хоорондын тооцоонуудын бичилтийг хийж цахим болон цаасаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж шалгуулан, нэгтгүүлж амжилттай хамгаалсан. | |
| 11. | **Арга хэмжээ 1.10** "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээллийг хүргэх" Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах | Улсын төсөв | Мэдээ, мэдээллийг олон нийтэд тухай бүр хүргэсэн хуулийн хэрэгжилтийн хувь | 2023 оны IV-р улирал, 2024 оны сар, улирал, хагас жил, тухай бүр оруулах төсөв, худалдан авах ажиллагааны мэдээлэл, төсөв, тайланг хуулийн хугацаанд 100 хувиар байршуулсан. | 2024 оны 12 сар, IV-р улирал, 2025 оны мэдээ, тайланг байгууллагын цахим хуудас, шилэн дансанд нийтлэх мэдээллүүдийг байршуулж, хэрэгжилтийг хангуулна. | -Газрын даргын баталсан хуваарийн дагуу агентлагийн 2024 оны 12 сар, IV дүгээр улирлын тайлан, 2025 оны 1-11 сар, I, II, III дугаар улирлын тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, тухайн жилийн төсөвт өөрчлөлт орсон нэмэлт өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн хамт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, санхүүгийн тайлангуудыг Шилэн дансны тухай хуулийн хугацаанд бүрэн байршуулж ажилласан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Худалдан авалтуудын тушаал шийдвэр гэрээ болон бусад баримтуудыг скайнердэж FDP болгон оруулж шилэн дансны мэдээллийг 100 хувь бүрэн байршуулж ажилласан.<br>Мөн харьяа байгууллагуудад шилэн дансны мэдээллийг сар болгоны 6-ны дотор байршуулахыг анхааруулж ажилласан. | |
| 12. | **Арга хэмжээ 1.11** Олон улсын стандартын шаардлагыг хангасан ус, цаг уурын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч компанитай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангаж<br>ажиллах | Улсын төсөв, төслийн санхүүжилтээр | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар | 2024 онд Финландын "Vaisala Oyj" компанитай цаг уурын хэмжих хэрэгсэл ху далдан авах гэрээ, Францын "MODEM" компанитай аэрологийн зонд худалдан авах гэрээ, Англи улсын eOsphere Limited компанитай програм хангамжийн техник үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж ажилласан.<br>БНХАУ-ын улсын үйлдвэртэй гэрээ байгуулан ЦАЗН пуужин авах гэрээ хийгдсэн, татан авах ажлыг гүйцэтгэж байна. | Тухайн компанитай 2025 онд гэрээ байгуулан багаж, тоног төхөөрөмжийг худалдан авч нийлүүлэн улсын сүлжээнд нэвтрүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. БНХАУ-ын улсын үйлдвэрээс ЦАЗН үйл ажиллагаанд хэрэглэх пуужинг татан авах ажлыг гүйцэтгэнэ.<br>Гэрээнүүдийн хэрэгжилт 100% байна. | Ус цаг уурын судалгаа шинжилгээний хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн талаар: 2025 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу газрын даргын 2025 оны газрын даргын А/81 тушаалаар М10 Аэрологийн радио зондын төлбөрт 414,256.6 мянган төгрөг, А/50 тушаалаар гааль НӨАТ-ын төлбөрт 61,530.7 мянган төгрөг нийт 475,787.3 мянган төгрөг, Газрын даргын 2025 оны А/59 дүгээр тушаалаар Их Британ улсын Еосфор компанид "Хиймэл дагуулын мэдээ шууд хүлээн авах VxEos систем болон SIBELIUS Data CUBE системүүдийн программын тасралтгүй ажиллагааг хангах" ажлын төлбөрт 24,020.0 мянган төгрөг, Газрын даргын 2025 А/103 тушаалаар тус газар болон БНХАУ-ын Цаг уурын газрын хооронд "Цаг уурын салбарт хамтран ажиллах хамтарсан ажлын хэсгийн XVI уулзалтын протокол"-ын дагуу Өмнөговь аймгийн УЦУОШТ-д нийлүүлэгдсэн аэрологийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | радио зонд бөмбөлөгийн гааль, НӨАТ, ачааны төлбөрт нийт 141,848.2 мянган төгрөгийг тус тус зарцуулж, төлбөр тооцоог нь хянаж хугацаанд нь шилжүүлж ажилласан. ЦАЗН үйл ажиллагаанд хэрэглэх 1200 ш пуужинг татан авах ажлыг зохион байгууллаа. | |
| | **Арга хэмжээ 1.12** Холбогдох конвенцийн хэрэгжилтийг хангах, Дэлхийн цаг уурын байгууллагаас баримталж буй бодлого, үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангах | Улсын төсөв | Дэлхийн цаг уурын байгууллага (ДЦУБ)-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангасан байдал, ДЦУБ-аас зохион байгуулсан олон улсын хурал, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | ДЦУБ-ын байнгын төлөөлөгчтэй холбогдох асуудлаар шууд харилцан хамтран ажиллаж байна. 2024 онд 120 албан хаагч сургалтанд хамрагдсан байна | Хамтын ажиллагааг өргөжүүлж үр дүнг нэмэгдүүлнэ. Сургалтанд хамрагдсан хүний тоо өссөн байна. | ДЦУБ-ын Сөүл дэх бүсийн сургалтын төвд Монгол Улсаас 2026 онд оролцох албан хаагчдын тоо болон 2025 онд “Синоптик инженерүүдийн чадавхыг бэхжүүлэх нь” сургалтад 3 албан хаагч, “Цаг уурын радарын инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх нь” сургалтад 2 албан хаагчдыг оролцуулав.<br>2025.02.07 болсон ДЦУБ-ын Цаг агаар, уур амьсгал, ус, далай, холбогдох байгаль орчны үйлчилгээ, хэрэглээний онцгой комиссын (SERCOM-Ext(2025)) ээлжит бус хуралдааны онлайн хурал,2025.02.12 ДЦУБ-ын 2 дугаар бүсийн 18 дугаар хурлын эхний үеийн цахим хуралд ГХЯ-аас итгэмжлэх болон сонгуулийн чиглэл авч ажилласан. ДЦУБ-аас 2025.03.10-2025.03.14 хүртэл Уур амьсгалын үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцооны(QMS) дотоод аудиторуудыг сургах онлайн семинарт Г.Амгаланг нэр дэвшүүлэн оролцуулсан. 2025.03.23 Дэлхийн Цаг Уурын Өдөрт зориулан ДЦУБ болон 2 дугаар бүсийн гишүүн орнуудад баярын мэндчилгээ явуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025.03.24 Газрын даргын үүрэгт шинээр томилогдсон Э.Баттулгын гадаад намтрыг албан бичгийн хамт боловсруулж, ГХЯ-нд хүргүүлэн ДЦУБ-ын байнгын төлөөлөгч болгон солиулсан.<br>2025.04.18 ДЦУБ болон БНХАУ-ын Цаг уурын албатай хамтран зохион байгуулдаг "Азийн бүсийн уур амьсгалын мониторинг, үнэлгээ ба урьдчилсан төлөв" сэдэвт 21 дэх удаагийн олон улсын бага хуралд Монгол Улсын төлөөлж Б.Жаргалангийн зардал, томилолтыг шийдвэрлүүлэн оролцуулсан.<br>2025.01.22 Африк-Азийн бүсэд байгалийн олон төрлийн гамшгийн эрсдэлээс эрт сэрэмжлүүлэх цогц систем (RIMES)-ийн байгууллагаас зохион байгуулсан "Сайд нарын түвшний 4 дүгээр хуралдаан"-д газрын дарга Э.Баттулга болон Л.Оюунжаргал нарын оролцох бэлтгэл ажлыг ханган оролцуулсан.<br>ДЦУБ-аас нийт 27 гадаад албан бичиг газрын цахим хаягт ирж холбогдох мэргэжилтэн болон дарга нарт танилцуулсан. | |
| | **Арга хэмжээ 1.13**<br>Цаг уур, орчны шинжилгээний газрын хоёр талын хамтын ажиллагаатай ОХУ-ын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний газар, БНХАУ-ын Цаг уурын газар, БНСУ-ын Цаг уурын газрын хооронд хамтран ажиллах протоколын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хамтран | Улсын төсөв, Хамтран ажиллах орны тухайн байгууллагын төсөв | Хоёр талын хамтын ажиллагаатай орнуудын хооронд хамтран ажиллах протоколын хэрэгжилтийн хувь | ОХУ-ын Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт Хамтарсан ажлын хэсгийн 9 дүгээр, БНХАУ-тай байгуулсан 16-р, БНСУ-тай байгуулсан 10 дугаар уулзалтыг | ОХУ-ын Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт Хамтарсан ажлын хэсгийн 9 дүгээр уулзалтын протоколын хэрэгжилтийг хангаж дүгнэх харилцааг сэргээх, БНХАУ-тай | Оросын Холбооны Улсын Цаг уурын албатай холбоо тогтоохоор боломжит харилцах байгууллага болох ОХУ-ын Ус, цаг уурын их сургуулийн (RSHU) Олон улсын боловсон хүчнийг сонгон шалгаруулах, эрдмийн хөдөлгөөний тэнхимийн дарга Ноён Доуголи Винсэнтэд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг үнэлэх, уулзалт хийх | | | протоколын хэрэгжилтийг хангах ажлыг тус тус зохион байгуулж, дүгнэх ажлыг хийж байна. Хэрэгжилт 90-93% | байгуулсан 16-р уулзалтын протоколын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, 17 дугаар уулзалтыг Монголд зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган протоколыг боловсруулж, батлуулах, БНСУ-тай байгуулсан 10 дугээр уулзалтын протоколын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, 11 дүгээр уулзалтад оролцох, саналаа тусгах батлуулах Хэрэгжилт 93-96% хүргэнэ. | хүсэлт тавьж одоогоор ОХУ-ын Цаг уурын албаны Гадаад харилцааны албан хаагч хатагтай Татьяна Дмитриева-н цахим хаягийг хүлээн авсан бөгөөд хамтран ажиллах, харилцаа холбоогоо сэргээх хүсэлтийг цахим шуудан явуулан холбоо тогтоохоор ажиллаж байна. **БНСУ-ын** Цаг уурын албатай хоёр талт хамтын ажиллагааны X протоколын хэрэгжилтийг гарган XI протоколыг шинээр боловсруулж БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 5 дугаар сарын 20-д айлчлалыг зохион байгуулан Монгол талын төлөөлөгчид амжилттай оролцон хамтын ажиллагааг илүү өргөтгөсөн XI протоколыг баталгаажуулдаа. БНХАУ-ын Цаг уурын албатай Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах XVII протоколын хүрээнд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Говь Алтай аймгийн Алтай хотод болон Өмнөговь аймгийн Даланзадгад хотын УЦУОШТ-үүдэд агаар мандлын дээд давхаргын ажиглалт буюу аэрологийн станц суурилуулах ажил хийгдэж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд БНХАУ-ын мэргэжилтнүүд болон холбогдох төвийн дарга нартай хамтран ажиллаж байна. Энэхүү XVII протоколыш дүгнэх, XVIII протоколыu шинээр боловсруулан батлах ажлыг 2025 онд Монголын талд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.14** Цаг уур, орчны шинжилгээний газар болон Тайландын Хааны бороо, хөдөө аж ахуйн агаарын тээврийн газар хооронд "Цаг агаарт зориудаар нөлөөлөх талаарх техникийн хамтын ажиллагааны хамтарсан хөтөлбөр"- ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Цаг уур, орчны шинжилгээний газар болон Тайландын Хааны бороо, хөдөө аж ахуйн агаарын тээврийн газар хооронд "Цаг агаарт зориудаар нөлөөлөх талаарх техникийн хамтын ажиллагааны хамтарсан хөтөлбөр" - ийн хэрэгжилт, хувь | "Монгол Улсад Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх" төслийг боловсруулж, Тайландад суугаа МУ - ын элчин сайдаар дамжуулан Тайландын засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байна. Хамтын ажиллагааны хүрээнд цахим болон 2 улсад харилцан мэргэжилтэнүүд/ 35 албан хаагч/ сургалтанд хамрагсан байна | Тайландын "Хааны бороо" байгууллагаас 10 мэргэжилтэн ЦУОШГ -т болон Өмнөговь аймагт ирж ажиллана. Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын үр дүнг үнэлэх системийг боловсруулж, туршисан байна Хоёр талын хамтын ажиллагааны хөтөлбөрийг сунгах, шинээр хэрэгжүүлэх ажлыг харилцан тохиролцож оруулах, өмнөх хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх | Монгол Улсын Цаг уур, орчны шинжилгээний газар болон Тайландын Хаант улсын Хааны бороо, хөдөө аж ахуйн нисэхийн газар хоорондын Цаг агаарт зориудаар нөлөөлөх тухай техникийн хамтын ажиллагааны хамтарсан үйл ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулах үйл явц 2025.06.22-2025.06.28 өдрүүдэд Монгол Улсад айлчлах үеэр зохион байгуулагдахаар төлөвлөгдөж байна. Тайландын Хаант улсын Хааны бороо, хөдөө аж ахуйн нисэхийн газар хоорондын Цаг агаарт зориудаар нөлөөлөх тухай техникийн хамтын ажиллагааны хамтарсан үйл ажиллагааны хүрээнд 6.24-28-ны хооронд 5 төлөөлөгч Монголд ирж, Өмнөговь аймагт ажиллах бөгөөд уг ажлыг тухайн аймгийн Засаг даргын Тамгын газар, газар, аймгийн УЦУОШТ-үүд хамтран зохион байгуулна. | 70 |
| | **Зорилт 2:** "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээллийг хүргэх" "Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, төсвийн удирдлагаар хангаж, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах", нээлттэй байх, Газрын үйл ажиллагаанд ISO9001 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлэх | Улсын төсөв | Мэдээ, мэдээллийг олон нийтэд тухай бүр хүргэсэн байдал, Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, | Жил, сар, тухай бүр оруулах төсөв, худалдан авах ажиллагааны мэдээлэл, төсөв, тайланг хуулийн хугацаанд нь байршуулсан Салбар байгууллагын нягтлан бодогчид, аж ахуйн няравд нягтлан бодох | 2024 онд байгууллагын цахим хуудас, Шилэн дансанд нийтлэх мэдээллүүдийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна. Газар болон харьяа байгууллагын 2023 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2024 оны эхний хагас | 2025 оны эхний хагас жилийн байгууллагын цахим хуудас, Шилэн дансанд нийтлэх мэдээллүүдийг хариуцан оруулах албан хаагчдын нэрсийг газрын даргын тушаалаар батлуулсантай холбоотой хуулийн хугацаанд бүрэн байршуулахад хяналт тавин ажилласанаар бүрэн хийгдсэнбайна. Газар болон харьяа байгууллагын 2024 оны жилийн эцсийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулалтад хяналт тавьсан байдал, хувиар | бүртгэлийн хөтлөлт, тайлан баланс гаргахад зөвлөмж өгч ажилласан. Газар болон харьяа байгууллагын 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж Сангийн яамны Э-тайланд шивж, төсвийг төвлөрүүлсэн | жилийн санхүүгийн тайланг нэгтгэн Сангийн яамны Э-тайланд шивж, төсвийг төвлөрүүлэн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн байна, Газрын үйл ажиллагаанд ISO9001 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлнэ | аудитлагдсан санхүүгийн тайлан, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн Сангийн яамны Э-тайланд шивж, төсвийг төвлөрүүлэн захирагчийн гүйцэтгэлийн тайланг яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн байна, Газрын үйл ажиллагаанд ISO9001 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлэхэд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг 2 мэргэжилтэнг ажлын хэсэгт ажилуулан, сургалтанд хамруулж ажиллаа. | |
